

**БАТЛАВ.**

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

**Н. ЦЭРЭНБАТ**

**БАТЛАВ.**

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Ц.НЯМДОРЖ**

## **ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

### **НЭГ.ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА**

#### **I.Хууль зүйн үндэслэл, шаардлага:**

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзугадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...Монгол Улсын иргэн ... “эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэЦ” гэж;

Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т Засгийн газар ...:4/ хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах гэж;

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “ой...зэрэг байгалийн баялаг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг хуулиар болон төрийн захиргааны байгууллагаас олгосон эрхийн дагуу эрхлэн зохицуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн байгууллага гэнэ” гэж;

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “ – ийн “тав. Эрх чөлөөтэй Монгол хүн” бүлэгт “ ... төрийн үйлчилгээг нийтийн үйлчилгээ болгон үндсээр нь өөрчилөх..”,... зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлж, зөвшөөрөл, лиценз авдаг олон шат, дамжлагыг энгийн хэлбэрт оруулах” гэж тус тус заасан нь төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

#### **II.Практик үндэслэл, шаардлага:**

Өнөөдөр ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу зохицуулж байна. Энэ хуулиудад заасны дагуу мэргэжлийн байгууллагын эрх олгох асуудлыг Засгийн газрын 2006 оны 37 дугаар тогтоолоор баталсан журмаар, Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журмыг Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-223 дугаар тушаалаар баталсан “ Ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлага, ажиллах журам”–р зохицуулж байна.

Оид явуулах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд хийх онцлог, олон улсын жишиг, чиг хандлагыг өөрчлөхгүйгээр ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох

зөвшөөрлийн системийг хөнгөвчлөх, иргэд, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх нь 2015 онд Монгол Улсын Их Хурлаас баталсан “Ойн талаар төрөөс баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх үндсэн шаардлага болон тавигдаж байна.

Ой модны салбар нь шилжилтийн эдийн засгийн жилүүдэд хамгийн их уналтанд орж, 2000–аад оны дунд үеэс ойн мэргэжлийн байгууллагын эрх олгох механизмыг нэвтрүүлж, зарим ахиц өөрчлөлт гарсан хэдий ч өнөөдрийг хүртэл техник, технологийн шинэчлэл хийгдээгүй мэргэжилтэй боловсон хүчний хувьд дутагдалтай хэвээр байгаа билээ.

Хорь орчим аж ахуйн нэгж, байгууллагын дунд түүвэр судалгаа хийж үзэхэд ой модны аж ахуйн нэгж компани нь 10-30 ажилчнтай, 2500-15000 га ойн талбайг эзэмшиж, жил дундажаар 2000 шоометр мод бэлтгэж, ашиглаж, 5-10 га талбайг ойжуулж байгаа нь туйлын хангалтгүй, амиа аргацаасан аж ахуйн хэлбэрээр оршин тогтох байгааг харуулж байна.

Техник, технологийн хувьд моторт хөрөө, гар багаж, бүтээмж муутай орчин үеийн шаардлага хангахгүй машин техникуудээр үйлдвэрлэл явуулж байна.

Ажилчдын 50.0 хувь нь ямарч дадлага сургалтанд хамрагдаагүй, 20.0 хувь нь нэг хүртэлх жилийн туршлагатай, 30.0 хувь нь цөөн хоногийн сургалтанд хамрагдсан, ажлын бүтээмж туйлын доогуур, ажиллагсадын байгаль орчинд ээлтэй технологийн талаарх мэдлэг хомс, мэргэжлийн ур чадвар дутмаг, хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж, эрүүл мэндээ хамгаалж ажилладаггүй байна.

Судалгааны дүнгээс үзэхэд дээр дурдсан нөхцөл байдлыг өөрчлөхийн тулд ойн аж ахуйн нэгжүүдийг мэргэжлийн өндөр түвшинд ажиллах суурь орчыг бүрдүүлэх, холбогдох журам стандартыг ханган мөрдөж байгаа эсэхийг үнэлэх, ойн мэргэжлийн байгууллагад тавигдах шаардлагыг үе шаттай ханглуулах эрх зүйн тааламжтай орчин бүрдүүлэх шаардлага ойн салбарын тулгамдсан асуудал болж байна.

Гэтэл яамны түвшинд ойн мэргэжлийн байгууллагын эрх олгож байгаа өнөөгийн систем нь дээр дурдсан шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, ойн салбарын магадлан итгэмжлэлийг бий болгосноор орон нутаг дахь ойн анги, ойн чиглэлийн дүрмийн зорилго бүхий ойн төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлсэнээр ойн тогтвортой менежментийг хангаж ажиллаж болохыг олон улсын байгууллага, бусад орны туршлага харуулж байна. Нөгөө талаас магадлан итгэмжлэлийг нэвтрүүлсэн боловсрол, эрүүл мэндийн салбарын туршлага нь ойн салбарт магадлан итгэмжлэлийг нэвтрүүлбэл тус салбарын тогтвортой хөгжлийг илүү хангаж болох итгэлийг төрүүлж байгаа болно.

## **ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ**

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 5 зүйлтэй байхаар төсөөлж байна.

Хуулийн төсөлд оруулсан өөрчлөлтийг тоймловол:

**1 дүгээр зүйлд** “магадлан итгэмжлэл”, “батламж” гэсэн нэр томъёог шинээр оруулж, ойн анги нь өөрийн харьяалах ойн сангийн газарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага болон эзэмшлийн ойн санд хийсэн магадлан итгэмжлэлийн тайланд санал өгөх, магадлан итгэмжлэлийг Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан Ойн магадлан итгэмжлэл хийх дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага хэрэгжүүлэх ба

магадлан итгэмжлэх шалгуур, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг ойн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах,

**2 болон 3 дугаар зүйлд** ойн мэргэжлийн байгууллага болон эзэмшлийн ойн санд хийсэн магадлан итгэмжлэлийг үндэслэн батламж олгох, сунгах, хүчингүй болгох эрхийг яаманд олгох, магадлан итгэмжлэлийг ойн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага төлбөртэйгээр хийх

**4 дүгээр зүйлд** энэ хууль батлагдахаас өмнө авсан ойн мэргэжлийн байгууллагын эрх нь гэрчилгээнд заасан хугацаанд хүчин төгөлдөр байх,

**5 дугаар зүйлд** хууль хүчин төгөлдөр байх хугацааг заах зэрэг заалтыг тус тус тусгана.

## **ГУРАВ. ХУУЛЬ БАТЛАГДСАНААР БИЙ БОЛОХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, ХУУЛЬ ЗҮЙН ҮР ДАГАВАР, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ**

Хууль батлагдсанаар ой модны салбарын хөгжлийг түргэтгэх, мэргэжилтэй боловсон хүчний хангамж, техник, технологийн чадавхийг нэмэгдүүлэх нөхцөл бүрдэх болно.

Ойн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт үлэмж сайжирч, иргэд, төрийн бус байгууллагын оролцох оролцоо нэмэгдэн, ойн ажилчид нь мэргэжлээ дээшлүүлдэг, гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа хангагдсан, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулдаг ойн аж ахуйн нэгжүүд бий болно.

Гэрээгээр эзэмшиж байгаа магадан итгэмжлэгдсэн ойн нөөц нэмэгдсэн, эрүүл, бүтээмжтэй, ойн биологийн янз хамгаалагдсан, нийгэм эдийн засгийн өндөр үр ашигтай байх нөхцөл хангагдаж, төр, иргэн, хувийн хэвшлийн байгууллага хоорондын хариуцлага дээшилж, чанарын мэдэгдэхүйц ахиц гарна гэж тооцож байна.

Монголын ойн магадлан итгэмжлэлийн системийг олон улсын “Хаалтан дахь нэрийн Монгол орчуулгыг оруулах...” \Program for the Endorsement of Forest Certification “PEFC”\ , “Монгол орчуулга...”, \Forest Stewardship Council “FSC”\ нэгтгэн олон улсын жишигт нийцсэн ойн салбарыг бий болгох, эдгээр байгууллагуудаас техник, технологи, хүний нөөцийг бэхжүүлэх чадавхийг нэмэгдүүлэх төслийн дэмжлэг авах эрх зүйн орчин бүрдэнэ.

**ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСӨЛ НЬ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН  
БУСАД ХУУЛЬТАЙ ХЭРХЭН УЯЛДАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР  
ЦААШИД ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ БУЮУ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ,  
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ХУУЛИЙН ТАЛААРХ САНАЛ.**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн бөгөөд төсөлтэй холбогдуулан ямар нэгэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, ямар нэг хуулийг хүчингүй болгох нөхцөл үүсэхгүй болно.

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ  
2017 оны ... дугаар сарын ... ны өдөр Улаанбаатар хот  
ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлд 3.1.25, 3.1.26 дахь хэсэг, 18 дугаар зүйлд 18.3.16 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.4 хэсэг болгон шинээр дор дурдсан агуулагатай шинэ заалт нэмсүгэй.

1\ 3 дугаар зүйлийн 3.1.25 дахь хэсэг:

“3.1.25. “магадлан итгэмжлэл” гэж үйл ажиллагааны түвшин, чанарт хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээ хийж дүгнэлт гаргасныг”;

2\ 3 дугаар зүйлийн 3.1.26 дахь хэсэг:

“ 3.1.26. “ батламж” гэж үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, эзэмшлийн ойн сан, байгууллага нь хууль тогтоомж, эрх зүйн бусад актаар тогтоосон чанар, стандартын шаардлагад нийцэж байгааг нотолсон дүгнэлт, магадлан итгэмжлэлийг үндэслэн эрх бүхий байгууллагаас олгож буй баримт бичгийг;”

3\ 18 дугаар зүйлийн 18.3.16 дахь хэсэг

“18.3.16. өөрийн харьяалах ойн сангийн газарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага болон эзэмшлийн ойн санд хийсэн магадлан итгэмжлэлийн тайландаан санал өгөх;”

4\ “ 23.4. Магадлан итгэмжлэлийг Ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан Ойн магадлан итгэмжлэл хийх дүрмийн зорилго бүхий төрийн бус байгууллага хэрэгжүүлэх ба магадлан итгэмжлэх шалгуур, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, холбогдох зардлын жишгийг ойн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

**2 дугаар зүйл.** Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.2.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1\ 13 дугаар зүйлийн 13.1.10 дахь хэсэг:

“ 13.1.10. ойн мэргэжлийн байгууллага болон эзэмшлийн ойн санд энэ хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 , 23.4 дэх хэсэгт заасны дагуу хийсэн магадлан итгэмжлэлийг үндэслэн батlamж олгох, сунгах, хүчингүй болгох”

2\ 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг:

“ 23.1. Ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх, ойн тооллого, зохион байгуулалт хийх, ойн хортон, өвчний судалгаа хийх, тэмцэл явуулах үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд явуулах, арга зүйн зөвлөлгөөгөөр хангах үүрэг бүхий магадлан итгэмжлэл хийлгэж, батlamж авсан аж ахуйн нэгж, байгууллагыг ойн мэргэжлийн байгууллага гэнэ.”

3\ 40 дүгээр зүйлийн 40.2.1 дэх хэсэг:

“ 40.2.1. магадлан итгэмжлэл хийлгэсний үйлчилгээний төлбөр;

**3 дугаар зүйл.** Ойн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.5 дахь хэсгийн “...байгууллагын гэсний дараахь “эрх” гэснийг “батlamж” гэж, “...уг” гэсний дараахь “эрхийн бичиг” гэснийг “батlamж” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Энэ хууль батлагдахаас өмнө авсан ойн мэргэжлийн байгууллагын эрх нь гэрчилгээнд заасан хугацаанд хүчин төгөлдөр байна.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА